



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, олгохыг
дэмжээгүй тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.2 дугаар зүйлийн 11, 8.1 дүгээр зүйлийн 13.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 7 дугаар зүйлийн 7.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.3, 19.14.3, 19.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын 2025 оны "Тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн батлах тухай" А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах тусгай зөвшөөрлийн комиссын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагын жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл шинээр олгохыг дэмжээгүй байгууллагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Г.Цэцэнсанаа), Чанарын хяналтын газар (Ч.Отгонцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЭРДЭНЭБАЯР

1525 010160

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын
газрын даргын 20.08 оны 08 дугаар сарын 07 -ны
өдрийн 17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
160



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хугацаа
1.	НЕОНГЭГЭЭ ХХК РД: 5025656	Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох-ханган нийлүүлэх	Баянзүрх дүүрэг, 17 дугаар хороо, Маршал таун хотхон, Кинг тауэр 143/01-р байр 2 давхар 10 тоот	2028.08.01
2.	СВИЙТ СЭКРИТ ХХК РД: 6015484	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, импортлох-ханган нийлүүлэх	Хан-Уул дүүрэг, 17 дугаар хороо, Стандион оргил /17012/ Их монгол улс гудамж 714 байр 1В	2028.08.01
3.	АМИРА СКАЙ ХХК РД: 8433054	Эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, 40 50 мянгат, Тэрх цагаан нуур оффис, 166 тоот	2028.08.01
4.	МОДЕРН ХЕЭЛТ САППЛЕЙ ХХК РД: 7124073	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх	Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Нарлаг өргөө хотхон, Нийслэл хүрээ өргөн чөлөө 726 байр, 5 давхарт	2028.08.01
5.	ПАРМА СЕНТ МОНГОЛИА ГХОХХК РД: 7171545	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох-ханган нийлүүлэх	Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо зайсан /17023/, Дүнжингарав гудамж 18 байр, А блок, 7 давхар, 702 тоот	2028.08.01

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

160



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХЫГ ДЭМЖЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Тусгай зөвшөөрөл хүссэн чиглэл
1.	ХЕЛП САПЛАЯ ХХК РД: 7124097	Эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх